



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 27 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 27 дугаар хуралдааныг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 27 дугаар хуралдаанаар /2025-12-26/ Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагын талаар авах зарим арга хэмжээний тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж, мэдэгдэл хүргүүлэх тухай ажлын албаны дүгнэлтийн тухай-Спэйссэл монголиа ГХО ХХК) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 12 (Тогтоол №274-285, 2025-12-26) тогтоолыг тус тус батлан шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 27 дугаар хуралдаанаар тус хорооны ЗУХАГ, Санхүүгийн хэлтэс, Хуулийн хэлтэс хамтран “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагын талаар авах зарим арга хэмжээний тухай” асуудлыг боловсруулан холбогдох тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээний төлбөрийг Аудитын зөвлөмжийн дагуу бага үнийн дүнтэй авлагуудыг данснаас хасах; илүү төлөлтийг өр төлбөртэй зөвшөөрлийн төлбөрт шилжүүлэн тооцох; найдваргүй авлагаас хасагдуулах; тодорхойгүй орлогоос тодруулж хаах; тооцооны залруулгаар; албан тоотын дагуу; шүүхийн шийдвэрээр; гэрээний тусгай нөхцөлөөр хасагдуулах насжилт өндөртэй төлбөрийг данснаас хасах зэрэг асуудлыг багтаасан танилцуулга, тогтоолын төсөл, хавсралтын хамт хэлэлцүүлэв. Тус хуралдаанаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.10 дахь хэсэг, Иргэний хуулийн 75 дугаар зүйл 75.1, Харилцаа холбооны зохицуулах хорооны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 3.3.3-ийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 274 тоот “Дансны авлагын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталж, энэхүү тогтоолын хавсралтаар “2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дансны авлагад тохируулга хийх 180 /нэг зуун наяд/ тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ, тохирлын гэрчилгээний төлбөрийг аудитын зөвлөмжийн дагуу бага үнийн дүнтэй авлагуудыг данснаас хасах, илүү төлөлтийг өр төлбөртэй зөвшөөрлийн төлбөрт шилжүүлэн тооцох, найдваргүй авлагаас хасагдуулах, тодорхойгүй орлогоос тодруулж хаах, тооцооны залруулгаар, албан тоотын дагуу, шүүхийн шийдвэрээр, гэрээний тусгай нөхцөлөөр хасагдуулах зэрэг шалтгаанаар нийт 169,108,569.34 /Нэг зуун жаран есөн сая нэг зуун найман мянга таван зуун жаран есөн төгрөг гучин дөрвөн мөнгө/, насжилт өндөртэй 176,447,395 /нэг зуун далан зургаан сая дөрвөн зуун дөчин долоон мянга гурван зуун

ерэн тав/ төгрөгийг данснаас хасаж тайлагнахыг ЗУХАГ, Санхүүгийн хэлтэст тус тус даалган шийдвэрлэв.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 27 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Бүртгэлийн гэрчилгээ хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт болон Хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзаж, мэдэгдэл хүргүүлэх тухай ажлын албаны дүгнэлтийн тухай-Спэйссэл монголиа ГХО ХХК болон холбогдох ажлын хэсэг, бүтцийн газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 11 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 11 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 275 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Монгол Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам ХХК /ГХО/: Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Хот, хот хоорондын суурин ярианы үйлчилгээ эрхлэх/) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 276 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Эн Би Си ХХК: Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх /Хот, хот хоорондын суурин ярианы үйлчилгээ эрхлэх/ болон дугаарлалт 711х-xxxx) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 277 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 3 хуулийн этгээдэд 3 тусгай зөвшөөрлийг (Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх") 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 278 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Тугтан гранд ХХК: “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 279 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 3 тусгай (Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх, /Интернэт/ 13600148 тоот; Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах /Интернет/ Улаанбаатар хот болон 21 аймаг, 23700051 тоот; Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах /Интернет/

Улаанбаатар хот, 23700052 тоот тусгай зөвшөөрлийг) зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 280 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 12 хуулийн этгээдийн 12 тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Ворлд бридж ложистик ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 281 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Ворлд бридж ложистик ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200205 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Би Ти Эс ложистик ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 282 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Би Ти Эс ложистик ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200206 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 283 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд (Эм Би Си монголиан бизнес консалтинг ХХК: 1900-8888) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарыг 2 жилийн хугацаагаар олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 284 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд олгосон (Амар даатгал ХХК: 1800-2111) 1 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилээр сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.9 дэх заалт, Хүйсийн тэгш эрх төв НҮТББ-ын хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 285 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай дугаарын (Хүйсийн тэгш эрх төв НҮТББ: 1800-1903 дугаарлалт бүхий 30010713 тоот) тусгай дугаар ашиглах гэрээг хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 27 дугаар хуралдаанд тусгай зөвшөөрлийн тухай асуудлын хүрээнд Спэйссэйл монголиа ХХК /ГХО/ компанийн 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийн хүсэлтийн талаар ажлын албаны болон хууль эрхзүйн дүгнэлт, хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзах тухай албан мэдэгдлийн төслийг тус тус танилцуулав. Энэхүү асуудлаар, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1, 5.2 дугаар зүйлийн 9, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 143 тоот тогтоолын хавсралтаар баталсан Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (интернэтийн үйлчилгээ)-ын 2.1, 2.7-д заасныг тус тус үндэслэн хүсэлтийг

шийдвэрлэхээс татгалзсан албан мэдэгдлийг Хорооны даргын гарын үсэгтэй албажуулан хүргүүлэхээр тогтов.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-12-28